



АУДИТЫН КОД: ХЭА-2017/1/САГ-ТЕЗ

**ХЭНТИЙ АЙМГИЙН ТЕЗ-ИЙН
2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-ЭЭР
ДУУСВАР БОЛСОН САНХҮҮГИЙН
НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН**

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

2017 ОН

	АГУУЛГА
Тайланг хянасан:	Товчилсон үгийн жагсаалт3
ҮАГ-ын харъяа	Нэг. Ерөнхий зүйл
Хэнтий аймгийн	Аудит хийсэн үндэслэл, хугацаа.....6
аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ.....6
Газрын дарга,	Аудитын арга зүй.....6
Тэргүүлэх	Хэнтий аймгийн ТЕЗ-ийн төсвийн 2016 оны санхүүгийн тайланг
аудитор:	нэгтгэхэд баримталсан бодлого, аргачлал.....6
Ц.Энхтүвшин	Хоёр. САНХҮҮГИЙН ДОТООД ХЯНАЛТ7
Аудитын	Гурав. Шилэн дансны мэдээлэл.....8
менежер:	Дөрөв. Материаллаг байдлыг тодорхойлох.....8
Б.Наранцэцэг	Тав. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар.....8
Тайланг бэлтгэсэн:	Зургаа. МӨНГӨН ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛ, ТАЙЛАГНАЛ
Ахлах аудитор:	6.1. Мөнгөн хөрөнгийн бүтцийн талаар9
Х.Еркегүл	6.2 Банкин дахь Хэнтий аймгийн ТЕЗ-ийн харилцах
Шинжээч:	дансны талаар.....10
М.Чулуун-Эрдэнэ	Долоо. Авлагын бүртгэл, тайлагнал
2016 оны 4 дүгээр	7.1. Авлагын бүтэц, дамжуулан зээлийн авлагын талаар.....12
сар	7.2. Авлагатай холбоотой зөрчлийн талаар14
Уг тайланг ҮАГ-ын	Найм. Бараа материалын бүртгэл, тайлагнал
Цахим хуудаснаас үзнэ үү:	8.1. Бараа материалын бүтэц, бүрэлдэхүүний талаар16
www.audit.mn	8.2 Төсөл, сангийн бараа материал дансны талаар.....17
	8.3 ОНӨҮГ-ын бараа материал дансны талаар.....17
	8.4 Сумдын ТЕЗ болон орон нутгийн төсөвт байгууллагуудын
	бараа материалтай холбоотой зөрчлийн талаар.....17
	Ёс. Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагнал
	9.1. Үндсэн хөрөнгийн бүтэц, бүрэлдэхүүний талаар.....19
	9.2 Сумдын ТЕЗ болон орон нутгийн төсөвт байгууллагуудын.
	үндсэн хөрөнгөтэй холбоотой зөрчлийн талаар.....21
	Арав. Өр төлбөрийн бүртгэл тайлагналын
	10.1. Өр төлбөрийн бүтцийн талаар22
	10.2 Өр, төлбөрийн дансны үлдэгдлийн баталгаажуулалтын
	талаар.....23

Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70562112 дугаарын утасаар харилцана уу.

ХАЯГ:

Үндэсний аудитын газрын харьяа Хэнтий аймгийн аудитын газар. Аймгийн ЗДТГ, Тэмүүжингийн гудамж, Хэнтий аймаг-23110 Монгол Улс

Арван нэг. Орлогын бүртгэл, тайлагнал

- 11.1 Хэнтий аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн талаар24
- 11.2 Сумдын ТЕЗ-ийн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан.....25
- 11.3 Орлогын данстай холбоотой зөрчлийн талаар.....25

Арван хоёр. Зардлын бүртгэл, тайлагнал

- 12.1 Зардлын бүртгэлийн талаар 26
- 12.2 Хэнтий аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар зардалтай холбоотой гарсан зөрчлүүдийн талаар.....28

Арван гурав: Хэнтий аймгийн ТЕЗ-ийн орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын бүртгэл, тайлагнал

- 13.1 ОНӨҮГ-ын талаар30
- 13.2 ОНӨмчит байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар төрийн өмчтэй холбоотой зөрчлийн талаар31

Арван дөрөв: Хэнтий аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийн талаар.....31

Арван тав. Өмнөх оны зөвлөмжийн хэрэгжилт.....34

Арван зургаа.Хэнтий аймгийн ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн санал, дүгнэлт..... 34

Арва долоо. Тайлант оны аудитын зөвлөмж34

Товчилсон үгийн жагсаалт

ААН	Аж ахуйн нэгж
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АЗЗА	Авто зам, засвар арчлалт
АИТХ	Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
АТӨЯХ	Авто тээврийн өөрөө явагч хэрэгсэл
АХБ	Азийн хөгжлийн банк
АХС	Аймаг хөгжүүлэх сан
БЗД	Багийн засаг дарга
БСГ	Боловсрол соёлын газар
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
БХС	Байгаль хамгаалах сан
БСШУС	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЖМС	Жижиг мөнгөн сан
ЖДҮХС	Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан
ЗГСНТ	Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан
ЗДНС	Засаг даргын нөөцийн сан
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МХС	Мал хамгаалах сан
НААХС	Нийтийн аж ахуйг хөгжүүлэх сан
НББ	Нягтлан бодох бүртгэл
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ОН	Орон нутаг
ОНӨААТҮГ	Хэнтий аймгийн ТЕЗ-ийнөмчит аж ахуйн төсөвт үйлдвэрийн газар
ОНӨҮГ	Хэнтий аймгийн ТЕЗ-ийнөмчит үйлдвэрийн газар
ОНСНТ	Хэнтий аймгийн ТЕЗ-ийнсанхүүгийн нэгтгэсэн тайлан

ОНХО	Хэнтий аймгийн ТЕЗ-ийнхөрөнгө оруулалт
ОНХОС	Хэнтий аймгийн ТЕЗ-ийнхөрөнгө оруулалтын сан
ОНХС	Орон нутгийг хөгжүүлэх сан
ОСНААУГ	Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газар
САГ	Санхүүгийн аудитын газар
СНТ	Санхүүгийн нэгтгэсэн тайлан
СС	Сангийн сайд
ССАЖС	Соёл, спорт, аялал жуулчлалын сайд
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
СХС	Сум хөгжүүлэх сан
СЯ	Сангийн яам
ТББ	Төрийн бус байгууллага
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон Хэнтий аймгийн ТЕЗ-ийнөмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТӨААН	Төрийн өмчит аж ахуйн нэгж
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТСГ	Төрийн сангийн газар
ТЭДС	Тариалан эрхлэлтийг дэмжих сан
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
УБҮ	Уулын баяжуулах үйлдвэр
УЗ	Улаан загалмай
УИХ	Улсын Их Хурал
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт
УУС	Уул уурхайн сайд
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ҮАГ	Үндэсний аудитын газар

ҮЭ	Үйлдвэрчний эвлэл
ҮХААС	Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд
ХАА	Хөдөө аж ахуй
ХАХНХС	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд
ХК	Хувьцаат компани
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХО	Хөрөнгө оруулалт
ХХС	Хүний хөгжил сан
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ЭЗХЯ	Эдийн засгийн хөгжлийн яам
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЭХС	Эрчим хүчний сайд

Нэг. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Аудит хийсэн үндэслэл, хугацаа

Үндэсний аудитын газрын харъяа Хэнтий аймгийн Аудитын газар Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-д заасан бүрэн эрхийн дагуу Хэнтий аймгийн төсвийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийлээ.

Аудитын зорилт, хамарсан хүрээ

Хэнтий аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт болон бусад шаардлагын дагуу бэлтгэж, ажил гүйлгээ нь түүнийг зохицуулж буй хууль, тогтоомжийн хүрээнд хийгдэж, үнэн шударга илэрхийлэгдсэн эсэх талаар үндэслэлтэй баталгаагаар хууль тогтоох байгууллагыг хангахад энэхүү аудитын зорилт чиглэгдлээ.

Хэнтий аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангууд иж бүрэн бөгөөд үнэн зөв болохыг тодорхойлсон батламж мэдэгдэл, тайлбар, нэмэлт тодруулгыг тэдгээр тайланд хавсаргах ёстой. Эдгээр мэдээллийг Аудитын олон улсын стандартын дагуу сорьж шалгах нь аудитын зорилт бөгөөд хамарсан асуудлууд болно.

Үндэсний аудитын газрын харъяа Хэнтий аймгийн Аудитын газар Хэнтий аймгийн ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж, санал дүгнэлт гаргахын өмнө Төсвийн тухай болон Төрийн аудитын тухай хуулийн дагуу 15 сумын төсвийн ерөнхийлөн захирагчдын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж, дүгнэлт гаргасан болно.

Аудитын арга зүй

Хэнтий аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй баталгаа олж авахын тулд санхүүгийн тайланг бэлтгэхэд баримталсан бодлого, зарчмыг үнэлж, хяналтын сорил, шинжилгээний горим болон нарийвчилсан сорил хийж, ихээхэн дүнтэй ажил гүйлгээ, тооцооллыг давтан шалгаж, санхүүгийн тайлан, түүний тодруулгад үнэлгээ өгөв.

Ингэхдээ санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийг үндсэн шалгуур болголоо.

Хэнтий аймгийн ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхэд баримталсан бодлого, аргачлал

Хэнтий аймгийн ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ УСНББОУС-д заасан зарчим, “Төсвийн тухай” хуулийн 54.1-54.4 заалт, Сангийн сайдын 2015 оны 341 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ыг баримтлан, “Төсвийн тухай” хуулийн 26.2 дахь заалт, “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 4.1, 7.2 дахь заалтуудын дагуу нягтлан бодох бүртгэлийн тохируулсан аккрузл суурийг хэрэглэж, Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлж гаргасан байна.

Хэнтий аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд дараах тайлангуудыг нэгтгэсэн байна. Үүнд:

- Сумын Төсвийн ерөнхийлөн захирагчдын 23 санхүүгийн нэгтгэсэн тайлан
- Орон нутгийн төсөвт 82 байгууллагуудын 2016 оны санхүүгийн тайлан
- Тусгай зориулалтын шилжүүлгийн 109 байгууллагын 2016 оны санхүүгийн тайлан

- Орон нутгийн өмчит үйлдвэрийн 42 газрын 2016 оны санхүүгийн тайлан
- Төсөл, сангийн 72 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Хэнтий аймгийн ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дараах бүрэлдэхүүнтэй:

А. Үндсэн тайлан:	Б. Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан	В. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тайлбар, тодруулга
Хэнтий аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх санхүүгийн байдлын тайлан	НББ-ийн бодлого, зарчим
Хэнтий аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх санхүүгийн үр дүнгийн тайлан	Толилуулгын суурь
Хэнтий аймгийн ТЕЗ-ийн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх мөнгөн гүйлгээний тайлан	
Хэнтий аймгийн ТЕЗ-ийн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	

Дээрх тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу “Төсөвт байгууллагын санхүүгийн тайлан” онлайн програмаар бэлтгэн гаргажээ.

Хоёр. Санхүүгийн дотоод хяналт

Төсвийн тухай хуулийн 14.2.10-т “Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитыг хэрэгжүүлнэ” гэж заасныг баримтлан төсвийн ерөнхийлөн захирагчдын бүтцэд дотоод аудитыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий “Санхүүгийн хяналт аудитын алба” байгуулагдсан байна.

Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2016 онд зарим сумдын 2015, 2016 оны эхний хагас жилийн санхүүд дотоод аудит хийж, төсвийн тухай хууль, түүнтэй холбогдон гарсан журмын хэрэгжилтийн дүнд нийтлэг илэрсэн зөрчил дутагдлыг засч, сайжруулах чиглэлээр зөвлөмж өгч ажилласан байна.

Хэнтий аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дотоод хяналтын эрсдэл “Хэвийн” гэж үнэлэгдсэн байна.

Гурав. Шилэн дансны мэдээлэл

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч нь “Шилэн дансны тухай” хуулийн 8.2, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан журамын 8.3 заалтыг удирдлага болгон хяналтыг хэрэгжүүлж байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилтэд шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийг хугацаанд нь тавьж байгаа эсэх болон мэдээллийн үнэн зөв бодитой байдалд сүлжээгээр тандан судлах, хяналт хийх удирдамж боловсруулан ажиллажээ.

ЗГ-ын 29 дүгээр тогтоолоор батлагдсан журмын 8.1 дэх заалтын дагуу “Шилэн дансанд мэдээлэл тавьсан албан тушаалтан, тухайн асуудал хариуцсан нэгж нь байршуулсан мэдээллээ улирал бүр ТЕЗ-ийн дотоод аудитын албанд дараа сарын 15-ны дотор тайлагнана” гэсэн заалтыг хэрэгжүүлж байна.

Хэдийгээр ТЕЗ-ийн дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт тавьж ажилладаг боловч зөвлөмжийн хэрэгжилтэд дүгнэлт хийж, хариуцлага тооцож ажиллахгүй байгаагаас аудитад хамрагдсан байгууллага, этгээд нь мэдээллийг бүрэн, үнэн зөв оруулдаггүй, хагас дутуу оруулдаг, эсвэл байхгүй гэж мэдээлдэг, төсвийн хэтрэлт, хэмнэлтийн шалтгааны тайлбарыг оруулдаггүй, хугацаа хоцроож мэдээлдэг зөрчил дутагдал байсаар байна.

Харин хуулийн 8.1-д зааснаар хөндлөнгийн хяналтыг бүх шатны ИТХ хэрэгжүүлэхээр заасан боловч аймаг, сумын ИТХ-аас хяналт тавьсан талаар мэдээлэл байхгүй байна.

Аймгийн аудитын газраас хийсэн нийцлийн аудитаар 2016 оны эхний 9 сарын байдлаар 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй 1582.6 сая төгрөгийн худалдан авалтыг мэдээлээгүй, 5 сая төгрөгөөс дээш 1159.0 сая төгрөгийн зарлагын гүйлгээг мэдээлээгүй, 5 сая төгрөгөөс дээш 13928.5 сая төгрөгийн орлогын гүйлгээг мэдээлээгүй, 216.7 сая төгрөгийн тушаал, шийдвэрийг мэдээлээгүй, гэрээгээр үүрэг гүйцэтгэгч ТББ нь 157.1 сая төгрөгийн санхүүжилтийг мэдээлээгүй зэрэг **нийт 17043.9 сая** төгрөгийн гүйлгээтэй холбоотой мэдээллийг байршуулаагүй ба хугацаа хоцроосон, мэдээллийг хагас дутуу оруулсан зэрэг зөрчил илрүүлснээс холбогдох ТЕЗ, албан тушаалтанд зөрчлийг арилгах 4 зөвлөмж, 44 албан тушаалтанд хариуцлага тооцох саналыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлснээс 63,4 хувь нь хэрэгжүүлсэн байна.

“Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилтийн талаар 2016 онд УАГ-НАГ/2016/04-НА-ХЭ кодтой нийцлийн аудитыг аймгийн Аудитын газраас хийсэн болно. АДБОУСтандарт-1620(P4)-ын дагуу аудитын тайлангаас холбогдох мэдээллийг авч ашиглав.

Дөрөв. Материаллаг байдлыг тодорхойлох

Хэнтий аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2016 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлын дүнг суурь болгон авч түүний 1.0 хувиар тооцон 737,4 сая төгрөгөөр тогтоов.

Тав. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар

Хэнтий аймгийн ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд бүх Орон нутгийн төсөвт байгууллага, Төрийн сан, орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, Төсөл, сангуудын нэгтгэлийн дүнг тус тусад нь харуулжээ.

Хэнтий аймгийн ТЕЗ-ийн төсвийн санхүүгийн нэгтгэсэн тайлан иж бүрэн бөгөөд үнэн зөв болохыг тодорхойлсон батламж мэдэгдэл, тайлбар, нэмэлт тодруулгыг тэдгээр тайланд хавсаргах ёстой.

Төсвийн тухай хуулийн 8.9.4-т “Аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 4 дүгээр сарын 20-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх” гэж заасны дагуу УАГ-ын харъяа Хэнтий аймгийн Аудитын газарт санхүүгийн нэгтгэсэн тайланг хуулийн хугацаанд нь эксэл файл, болон цаасан хэлбэрээр ирүүлсэн бөгөөд СТАУС програмд оруулж тулгалт хийж уялдааг шалгахад зөрүүгүй таарч байна.

Зургаа. Мөнгөн хөрөнгийн бүртгэл, тайлагнал

6.1 Мөнгөн хөрөнгийн бүтцийн талаар

Хэнтий аймгийн ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөд дараах зүйлсийг бүртгэж тайлагнасан байна. Үүнд:

- Орон нутгийн төрийн сангийн нэгдсэн дансны үлдэгдэл
- Төсөл сангийн төрийн сан банкинд байршдаг харилцах дансны үлдэгдэл
- ОНӨҮГ-уудын арилжааны банкинд байршдаг харилцах дансны үлдэгдэл
- Кассад байгаа бэлэн мөнгө.

Хэнтий аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 2015 оны эцэст 2152,4 сая төгрөг байснаас 2016 онд 9,1 хувиар буурч 1955,8 сая төгрөгөөр тайлагнасан бөгөөд үүний 2,8 хувь буюу 55,0 сая төгрөг нь арилжааны банкинд байршиж байна.

Хэнтий аймгийн ТЕЗ-ийн төсвийн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн 2016 оны үлдэгдлийг бүтэц, байгууллагын төрлөөр харуулбал:

(сая төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	Хувиар
Кассад байгаа бэлэн мөнгө	6.1	2.3	(3.8)	(62.2)
Төгрөг/ЖМС	6.1	2.3	(3.8)	(62.2)
Банкинд байгаа бэлэн мөнгө	2,146.3	1,953.5	(192.8)	(8.9)
Төгрөг	2,146.3	1,953.5	(192.8)	(8.9)
Төрийн сангийн харилцах	2,047.2	1898.5	(148.7)	(7.2)
Арилжааны банкин дахь харилцах	99.1	55.0	(44.1)	(44.5)
Нийт мөнгөн хөрөнгийн дүн	2,152.4	1,955.8	(196.6)	(9.1)
Үүнээс байгууллагын төрлөөр харуулбал:				

Төрийн сан	1334,2	775.5	(558.7)	(41.8)
Төсөвт байгууллагууд	334.0	591.0	257.0	76.9
ОН-ын өмчит үйлдвэрийн газар	63.8	57.3	(6.5)	(10.1)
Төсөл, сангууд	420.4	532.0	111.6	26.5
Нийт мөнгөн хөрөнгийн дүн	2,152.4	1,955.8	(196.6)	(9.1)

Хүснэгт-1

Оны эхний үлдэгдэлтэй харьцуулбал: Төсөвт байгууллагуудын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 257,0 сая төгрөгөөр, төсөл сангуудын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 111,6 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

6.2 Банкин дахь Хэнтий аймгийн ТЕЗ-ийн харилцах дансны талаар

Сангийн яамны Төрийн сангийн газраас Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.6-д заасны дагуу Монголбанк, банкинд төсвийн байгууллагын дансыг нээх, хаах, улсын төсвийн орлогын “тэг” үлдэгдэлтэй данс байршуулах зөвшөөрөл олгох харилцааг зохицуулах зорилгоор “Засгийн газрын болон төсвийн байгууллагын дансыг Монголбанк, банкинд нээх, хаах журам”-ыг шинээр боловсруулан Сангийн сайд, Монголбанкны ерөнхийлөгчийн 2013 оны 24/24/A-9 дүгээр хамтарсан тушаалаар батлуулан мөрдөж ажилласан байна.

Аймгийн ТЕЗ-ийн, төсвийн төвлөрүүлэн захирагч болон шууд захирагч нарын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг арилжааны банк, төрийн сан банкуудад баталгаажуулах захидал хүүргүүлж баталгаажуулахад зөрүү үүсээгүй байна.

Арилжааны банкуудад байршиж буй харилцах дансны үлдэгдлийг Хэнтий аймгийн ТЕЗ-ийн төсвөөр хураангуйлан харуулбал:

ХЭНТИЙ АЙМАГ	Үлдэгдэл			НИЙТ ДАНСНЫ ТОО	
	Төсвийн орлогын данс	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар	НИЙТ ҮЛДЭГДЭЛ мянган төгрөгөөр	Байгаа	Хаагдсан
Галшир сум	0.00	40.6	40.6	3	0
Баянхутаг сум	0.00	29.2	29.2	4	0
Баянмөнх сум	0.00	30.2	30.2	6	0
Дархан сум	0.00	36.9	36.9	4	0
Дэлгэрхаан сум	0.00	51.7	51.7	5	0
Жаргалтхаан сум	0.00	45.6	45.6	4	0
Цэнхэрмандал сум	0.00	874.9	874.9	6	0
Өмнөдэлгэр сум	0.00	26,371.0	26,371.0	6	0
Батширээт сум	0.00	6,382.2	6,382.2	6	0

Биндэр сум	0.00	927.3	927.3	6	0
Баянадрага сум	0.00	1,351.7	1,351.7	4	0
Дадал сум	0.00	0.00	0.00	3	0
Норовлин сум	0.00	123.8	123.8	5	0
Батноров сум	0.00	78.5	78.5	3	0
Баян-Овоо сум	0.00	1,576.0	1,576.0	3	0
Мөрөн сум	0.00	837.8	837.8	4	0
Хэрлэн сум	0.00	0.00	0.00	3	0
Гурванбаян тосгон	0.00	25.8	25.8	3	0
Бор-Өндөр сум	0.00	1,775.1	1,775.1	7	0
Өлзийт тосгон	0.00	239.8	239.8	3	0
Бэрх тосгон	0.00	1,245.5	1,245.5	3	0
Хэрлэн баян улаан тосгон	0.00	0.00	0.00	0	0
Аймгийн Төрийн сан	0.00	12,914.7	12,914.7	23	0
НИЙТ ДҮН	0.00	54,997.7	54,997.7	114	0

Хүснэгт-2

Санхүү байдлын тайлангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг төсвийн байгууллагуудаас хүлээн авсан санхүүгийн тайлантай тулган баталгаажуулахад мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл зөрүүгүй илэрхийлэгдсэн байна.

Хэнтий аймгийн ТЕЗ-ын санхүүгийн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар мөнгөн хөрөнгийн данстай холбоотой 39,6 сая төгрөгийн зөрчил илэрч, эдгээр нь тохиолдсон байх, толилуулга ба тодруулга, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна. Үүнд:

- Биндэр сумын СДОйн анги нь Төрийн банкаар төлбөрийн хүсэлтгүй 30,5 сая төгрөгийн гүйлгээ хийсэн
- Батширээт сумын ЗДТГазрын мөнгөн хөрөнгийн дансанд түүвийн аргаар анхан шатны баримтын бүрдэл, дансны бичилтийг үнэн зөв хийсэн эсэх, хууль тогтоомжийн мөрдөлтийг шалгахад засаг даргын нөөц хөрөнгөөс хоол, хүнсний материалын 1,8 сая төгрөгийн зардал гаргасан.
- Биндэр сумын ЗДТГазрын мөнгөн хөрөнгийн зарцуулалтыг түүврийн аргаар шалгахад 2 хүнд албан томилолтыг нийт 0,04 сая төгрөгөөр дутуу олгосон, байгууллагын нэмэлт данснаас 5,0 сая төгрөгийг анхан шатны баримтгүй, ЖДБДСангийн үйл ажиллагааг дэмжих зориулалтаар хүлэмжний үнийг компаний дансанд шилжүүлсэн боловч данс бүртгэлд тусгалгүй орхигдуулсан,

мөн засаг даргын нөөц хөрөнгөөс шинэ жилийн арга хэмжээний зардалд 2,2 сая төгрөгийг гаргасан.

Аудитаар нийт 39,6 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 4,0 сая төгрөгийн зөрчлийн арилгуулах албан шаардлага хүргүүлж, 30,5 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч 5,1 сая төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулсан байна.

Долоо. Авлагын бүртгэл, тайлагнал

7.1 Авлагын бүтэц, бүрэлдэхүүний талаар

Хэнтий аймгийн ТЭЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт авлагын эхний үлдэгдэл 8171,8 сая төгрөг байснаас тайлант онд 72,3 сая төгрөгөөр буюу 0,9 хувиар өсч, оны эцэст 8244,1 сая төгрөгөөр тайлагнагдсан байна.

Нийт авлагын үлдэгдлийг бүтэц, байгууллагын төрлөөр нь харуулбал:
(сая төгрөгөөр)

Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	Хувиар
Ажиллагчидтай холбогдсон авлага	3.6	5.0	1.4	38.8
Төлбөртэй үйлчилгээний авлага				
Дансны авлага /ТӨҮГ/	263.2	358.0	94.8	36.0
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	0.2	0.03	(0.17)	(85.0)
Байгууллагаас авах авлага	635.4	592.5	(42.9)	(6.7)
Хувь хүмүүсээс авах авлага	7,239.4	138.9	(7100.5)	(98.1)
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон	30.0	7149.7	7119.7	23732.3
НИЙТ ДҮН	8,171.8	8244.1	72.3	0.9
Үүнээс байгууллагын төрлөөр харуулбал:				
Төрийн сан	30,0	30,0	0	0
Төсөвт байгууллагууд	126.2	141.7	15.5	12.3
ОН-ын өмчит үйлдвэрийн газар	461.1	494.4	33.3	7.2
Төсөл, сангууд	7555.5	7578.0	22.5	0.3
НИЙТ ДҮН	8171.8	8244.1	72.3	0.9

Хүснэгт-3

Хэнтий аймгийн ТЭЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хувь хүмүүсээс авах авлага дансанд бүртгэлтэй зээлийн авлагыг 2016 онд зээлийн авлага дансанд шилжүүлэн нэгтгэсэн байна. Авлагын дансны үлдэгдлийг байгууллагын төрлөөр авч үзвэл нийт авлагын 0,4 хувийг төрийн сан, 1,7 хувийг төсөвт байгууллага, 6,0 хувийг ОНӨҮГ, 91,9 хувийг төсөл, сангийн

авлага буюу СХС, ЖДҮДС-аас олгосон зээлийн авлага эзлэж байна. Төсөвт байгууллагын авлага өссөн нь орон нутгийн болон тусгай шилжүүлгийн байгууллагын нэмэлт дансны үлдэгдлийг төвлөрүүлсний авлага өссөнтэй холбоотой юм.

Нийт авлагыг сум тус бүрээр хүснэгтээр харуулбал:

(сая төгрөгөөр)

Аймгийн нэрс	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	Хувиар
Галшир сум	266.90	283.80	16.90	6.3
Баянхутаг сум	266.90	278.80	11.90	4.5
Баянмөнх сум	298.30	266.20	-32.10	-10.8
Дархан сум	168.70	268.80	100.10	59.3
Дэлгэрхаан сум	269.70	279.20	9.50	3.5
Жаргалтхаан сум	254.10	257.70	3.60	1.4
Цэнхэрмандал сум	326.50	275.70	-50.80	-15.6
Өмнөдэлгэр сум	330.90	357.70	26.80	8.1
Батширээт сум	301.50	269.10	-32.40	-10.7
Биндэр сум	323.40	343.50	20.10	6.2
Баянадрага сум	276.00	249.80	-26.20	-9.5
Дадал сум	281.70	273.40	-8.30	-2.9
Норовлин сум	297.30	269.10	-28.20	-9.5
Батноров сум	279.40	300.80	21.40	7.7
Баян-Овоо сум	261.70	271.70	10.00	3.8
Мөрөн сум	276.10	277.20	1.10	0.4
Хэрлэн сум	1,500.10	1,508.70	8.60	0.6
Гурванбаян тосгон	54.70	58.10	3.40	6.2
Бор-Өндөр сум	901.70	867.90	-33.80	-3.7
Өлзийт тосгон	6.10	8.50	2.40	39.3
Бэрх тосгон	274.10	276.70	2.60	0.9
Хэрлэн баян улаан тосгон	11.10	8.50	-2.60	-23.4
Аймгийн Төрийн сан	944.80	993.20	48.40	5.1
Нийт дүн	8171.7	8,244.10	72.40	0.9

Хүснэгт-4

Дээрхи хүснэгтээс харахад: Оны эхний үлдэгдлээс Дархан сумын авлага 100,0 сая төгрөг буюу 59,3 хувь, Өлзийт тосгоны авлага 2,4 сая төгрөг буюу 39,3 хувь өссөн бол Цэнхэрмандал сумын авлага 50,8 сая буюу 15,6 хувь, Баянмөнх сумын авлага 32,1 сая төгрөг буюу 10,8 хувь, Батширээт сумын авлага 32,4 сая төгрөг буюу 10,7 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

*Хэнтий аймгийн ТЕЗ-ийн 2016 оны нийт авлагын үлдэгдлийг
сум тус бүрээр графикаар харуулбал:*




График-1

Дээрх графикаас харахад: Нийт авлагын дүнд Хэрлэн сум 18,3 хувь, Бор өндөр сум 10,5 хувь болон аймгийн төрийн сан 12,0 хувь буюу нийт 40,8 хувийг эзэлж байна.

7.2 Авлагатай холбоотой зөрчлийн талаар

Хэнтий аймгийн ТЕЗ-ийн орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, төсвийн байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар авлагын данстай холбоотой илэрсэн нийт 442,1 сая төгрөгийн алдаа, зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлийг заавал бүртгэнэ”, 14.4.2-д “Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, 20 дугаар зүйлийн 20.2.6 “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдэлийг баталгаажуулах, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалттай нийцээгүй буюу үнэн зөв байдал, оршин байх, эрх ба үүрэг, хэмжилт, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй, Сангийн сайдын 388 дугаар тушаалаар баталсан НББ-ийн зааварыг хэрэгжүүлж ажиллаагүйтэй холбоотой байна.Үүнд:

- Аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгддэг аймгийн “Орон сууц”-ны сангийн 309,1 сая төгрөг, “ЖДҮДС”-гийн 108,6 сая төгрөг, “Газар тариалан дэмжих сан”-гийн 4,9 сая төгрөгийн, “МЭХС”-гийн 6,4 сая төгрөгийн буюу нийт 429,0 сая төгрөгийн олон жилийн насжилттай авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.
- Баянмөнх сумын цэцэрлэг, Хэрлэн, Баянхутаг, Мөрөн сумын ЗДТГ-ууд нийт 4,2 сая төгрөгийн авлагыг бэлтгэн нийлүүлэгч, харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж, актаар баталгаажуулалгүйгээр санхүүгийн тайланд тусгасан.

- Дадал сумын ЕБС, Норовлин сумын ЗДТГ, ХГБХГ, аймгийн НҮГ зэрэг байгуллагуудад нягтлан бодох бүртгэл, тайлангналтай холбоотой 8,9 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна.

Авлагатай холбоотой зөрчлийг хүснэгтээр харуулбал:

(сая төгрөгөөр)

д/ д	Сумын нэр	Байгууллагын нэр	Насжилт өндөр	Баталгаажуулааг үй		Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой			
			Аудитаар авсан арга хэмжээ						
			Албан шаардлага	Зөвлөмж	Албан шаардлага	Залруулсан	Зөвлөмж	Албан шаард	Төлбөрийн акт
1	Хэрлэн сум	ЗДТГ		1,5					
2	Аймаг	НҮГ				0,7			
3	Баянмөнх сум	Цэцэрлэг				1,6			
4	Норовлин	ЗДТГ				0,2			
5	Дадал	ЕБС					7,9		
6	Баянхутаг сум	ЗДТГ		0,8					
7	Мөрөн сум	ЗДТГ		0,3					
8	Аймаг	Орон сууцны сан	309,1						
9	Аймаг	ЖДҮДСан	108,6						
10	Аймаг	МЭХСан	4,9						
11	Аймаг	Газар тариалан дэмжих сан	6,4						
12	Аймаг	ХГБХГазар							0,1
			429,0	2,6	0,0	2,5	7,9	0,0	0,1
Нийт дүн			442,1						

Хүснэгт-5

Аудитаар илэрсэн нийт 442,1 сая төгрөгийн алдаа, зөрчлийн 429,0 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар албан шаардлага хүргүүлж, 10,5 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч, 0,1 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 2,5 сая төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд залруулсан байна.

Найм. Бараа материалын бүртгэл, тайлагнал.**8.1 Бараа материалын бүтэц, бүрэлдхүүний талаар**

Хэнтий аймгийн ТЕЗ-ийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт бараа материалын эхний үлдэгдэл 4486,9 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 4993,9 сая төгрөгөөр тайлагнагдаж, тайланд онд 507,0 сая төгрөгөөр букуу 11,3 хувиар өссөн байна.

Нийт бараа материалын үлдэгдлийг бүтэц, байгууллагын төрлөөр нь харуулбал:

(сая.төгрөгөөр)

Бараа материалын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	Хувь
Тусгай зориулалтын материал	295.60	350.8	55.2	18.6
Эм боох материал	146.50	199.6	53.1	36.2
Дуусаагүй үйлдвэрлэл	10	10	-	-
Бэлэн бүтээгдэхүүн	0.10	2.4	2.3	-
Бичиг хэргийн материал	145.30	134.1	(11.2)	(7.7)
Аж ахуйн материал	1,767.90	1780.1	12.2	0.7
Сэлбэг хэрэгсэл	54.90	83.7	28.8	52.4
Түлш шатхуун, тослох материал	111.00	167.2	56.2	50.6
Барилга засварын материал	79.90	64.4	(15.5)	(19.3)
Хүнсний материал	171.20	243.3	72.1	42.1
Бусад хангамжийн материал	1,052.70	1,220.5	167.8	15.9
Мал амьтад	651.70	737.6	85.9	13.1
НИЙТ ДҮН	4,486.9	4993.9	507.0	11.3
Үүнээс: Байгууллагын төрлөөр харуулбал:				
Төрийн сан	0.00	0.00	0.00	0.00
Төсөвт байгууллагууд	3686.2	4414.1	727.9	19.7
ОН-ын өмчит үйлдвэрийн газар	733.5	544.6	(188.9)	(25.7)
Төсөл, сангууд	67.2	35.2	(32.0)	47.6
НИЙТ ДҮН	4,486.9	4993.9	507.0	11.3

Хүснэгт-6

Бараа материалын нийт өсөлтийг нэр төрлөөр нь авч үзвэл бичиг хэргийн материал 11,2 сая төгрөгөөр, засварын материал 15,5 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй бол бусад бүх материалын дансны үлдэгдэл 480,3 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Бараа материалын тодруулга тайлангийн үзүүлэлтийг хүснэгтээр харуулбал:

(Сая төгрөгөөр)

Үзүүлэлт	Түүхий эд материал	Дуусаагүй үйлдвэрлэл	Бэлэн бүтээгдэхүүн	Хангамжийн материал	Мал	Нийт дүн
Оны эхний үлдэгдэл	442,1	10,0	0,1	3,383,0	651,7	4486,9
Нэмэгдсэн	1061,2	0	18,6	6170,3	263,1	7513,2
Худалдан авсан	1010,9	0	18,6	5743,2	15,7	6788,4
Хандиваар	6,1	0	0	71,1	70,0	147,2
Шилжүүлэн авсан	31,8	0	0	229,0	48,2	309,0
Бусад	12,4	0	0	127,0	129,2	268,6
Хасагдсан	952,9	0	16,3	5859,7	177,2	7006,1
Зарцуулсан	938,6	0	16,3	5490,8	57,8	6503,5
Шилжүүлсэн	1,4	0	0	67,8	20,6	89,8
Бусад	12,9	0	0	301,1	98,8	412,8
Эцсийн үлдэгдэл	550,4	10,0	2,4	3693,6	737,6	4993,9

Хүснэгт-7

Тайлант онд бараа материал нийт 7513,2 сая төгрөгөөр нэмэгдсэнээс төсвийн болон өөрийн хөрөнгөөр худалдаж авсан 6788,4 сая төгрөгийн, хандив тусламжаар 147,2 сая төгрөгийн, шилжүүлж авсан 309,0 сая төгрөгийн бараа материал байгаа бол бусад хэлбэрээр 268,6 сая төгрөгийн бараа материал нэмэгдсэн байна.

Тайлант онд бараа материал нийт 7006,1 сая төгрөгөөр зарлагдсанаас 6503,5 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан буюу худалдсан, 89,8 сая төгрөгийн бараа материалыг шилжүүлсэн, бусад байдлаар 412,8 сая төгрөгийн бараа материалыг зарцуулжээ.

8.2 Төсөл, сангийн бараа материалын дансны талаар

Төсөл, сангийн бараа материалын жилийн эцсийн үлдэгдэл 35,2 сая төгрөг бөгөөд энэ нь малыг эрсдлээс хамгаалах сангийн үлдэгдэл байна. Төсөл, сангийн бараа материал нь 2016 оны нийт бараа материалын үлдэгдлийн 0,7 хувийг эзэлж байна.

8.3 ОНӨҮГ-ын бараа материалын дансны талаар:

ОНӨҮГ-ын бараа материалын жилийн эцсийн үлдэгдэл 544,6 сая төгрөг байгаагаас “Хэнтий-ус” ХХК нь 301,9 сая төгрөг буюу 55,4 хувь, үлдэх 242,7 сая төгрөг буюу 44,6 хувийг сумдын ЭЭС болон ойн ангиуд эзэлж байна. ОНӨҮГ-ын бараа материал нь 2016 оны нийт бараа материалын үлдэгдлийн 10,9 хувийг эзэлж байна.

8.4 Сумдын ТЕЗ болон орон нутгийн төсөвт байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар бараа материалтай холбоотой илэрсэн зөрчлийн талаар:

Аудитаар бараа материалын үлдэгдлийг зөрүүтэй тайлагнасан, буруу бүртгэсэн, данс бүртгэлд орлого авалгүй шууд зардалд бүртгэсэн, бараа материалыг анхан шатны баримтгүй болон бүрдэл дутуу баримтаар зарцуулсан, дотоод хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн зэрэг нийт 89,8 сая төгрөгийн зөрчил илэрч, толилуулга ба тодруулга, хэмжилт, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна. Тухайлбал:

- Баянмөнх, Жаргалтхаан, Бор-Өндөр, Биндсэр, Баянхутаг сумын ЗДТГазар нийт 83,8 сая төгрөгийн, Жаргалтхаан сумын ИТХ 1,3 сая төгрөгийн бараа материалын тооллогыг хийгээгүй, тооцоо бодоогүй, үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.
- Өмнөдэлгэр сумын ЭМТ 0,7 сая төгрөгийн, Баянмөнх сумын цэцэрлэг 0,4 сая төгрөгийн бараа материалыг анхан шатны баримгүйгээр зарлага гаргаж гүйлгээ хийсэн.
- Баянмөнх сумын ЭМТ нь 1,8 сая төгрөгийн бараа материалыг орлого, зарлагаар бүртгэлгүйгээр шууд зардалд хаасан.
- Жаргалтхаан сумын цэцэрлэг 0,2 сая төгрөгийн, ЗДТГ 1,4 сая төгрөгийн бараа материалыг бараа материалын тайланд дутуу тайлагнасан зэрэг зөрчлүүд илэрсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн, зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.6-д “ Анхан шатны баримтгүй ажил, гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион багуулах, удирдах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70.2 “Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана” гэсэн заалтуудыг болон “Эд хариуцагчийн эрх үүргийн дүрэм” – ийг зөрчсөн байна.

Бараа маериалтай холбоотой илэрсэн зөрчлийг хүснэгтээр харуулбал:

(сая төгрөгөөр)

Сумын нэр	Байгууллагын нэр	Дансны нэр	Зөрчлийн утга	Мөнгөн дүн	Аудитаар авсан арга хэмжээ
Баянмөнх сум	ЗДТГазар	Бараа материал	тооллоготой холбоотой	4,8	Зөвлөмж өгөх
Өмнөдэлгэр сум	ЭМТөв	Бараа материал	Бүртгэлтэй холбоотой	0,7	Зөвлөмж өгөх
Жаргалтхаан сум	ИТХурал	Бараа материал	тооллоготой холбоотой	1,4	Зөвлөмж өгөх
Бор-Өндөр сум	ЗДТГазар	Бараа материал	тооллоготой холбоотой	26,6	Зөвлөмж өгөх
Жаргалтхаан сум	Цэцэрлэг	Бараа материал	Бүртгэлтэй холбоотой	0,2	Санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд зарлуулга хийх
Биндэр сум	ЗДТГазар	Бараа материал	тооллоготой холбоотой	0,5	Зөвлөмж өгөх
Жаргалтхаан сум	ЗДТГазар	Бараа материал	Бүртгэлтэй холбоотой	1,4	Зөвлөмж өгөх
Жаргалтхаан сум	ЗДТГазар	Бараа материал	тооллоготой холбоотой	48,6	Зөвлөмж өгөх

Баянмөнх сум	ЭМТөв	Бараа материал	Бүртгэлтэй холбоотой	1,8	Зөвлөмж өгөх
Баянмөнх сум	Цэцэрлэг	Бараа материал	Бүртгэлтэй холбоотой	0,4	Санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд зарлуулга хийх
Баянхутаг	ЗДТГазар	Бараа материал	тооллоготой холбоотой	3,3	Зөвлөмж өгөх
Дүн				89,8	

Хүснэгт-8

Үүнээс: Нийт 89,8 сая төгрөгийн зөрчил илэрснээс 89,1 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч 0,6 сая төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулсан байна.

Ес. Үндсэн хөрөнгийн талаар**9.1 Үндсэн хөрөнгийн бүтэц, бүрэлдэхүүн, тайлагналын талаар**

Хэнтий аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үндсэн хөрөнгө 2015 оны эцэст 110057,4 сая төгрөг байсан бол тайлант онд 3,3 хувь буюу 3590,1 сая төгрөгөөр нэмэгдэж 2016 оны эцэст 113647,5 сая төгрөгөөр тайлагнагдсан байна.

Нийт үндсэн хөрөнгийн үлдэгдлийг бүтэц, байгууллагын төрлөөр нь харуулбал:

(сая төгрөгөөр)

Ангилал	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	
			дүн	Хувь
Газар	364.6	364.6	0	-
Барилга байгууламж	71,858.5	78,252.4	6393.9	8.9
Тээврийн хэрэгсэл	2,968.8	2,728.0	-240.8	(8.1)
Машин тоног төхөөрөмж	5,676.3	5,470.4	-205.9	(3.6)
Тавилга эд хогшил	2,615.9	2,610.3	-5.6	(0.2)
Дуусаагүй барилга	16,138.5	12,872.9	-3265.6	(20.2)
Зам, гүүрийн байгууламж	4,745.7	5,460.8	715.1	15.1
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	1,611.9	1,655.2	43.3	2.7
Бусад үндсэн хөрөнгө	3,262.3	3,498.5	236.2	7.2
Ном	734.8	669.3	-65.5	(8.9)
Биет бус хөрөнгө	80.1	58.8	-21.3	26.6)
Батлан хамгаалах тоног төхөөрөмж		6.3	6.3	
Дүн	110,057.4	113,647.5	3,590.1	3.3

Үүнээс байгууллагын төрлөөр харуулбал:				
Төрийн сан	0	0	0	0
Төсөвт байгууллагууд	102649.5	105984.4	3,334.90	3.25
ОН-ын өмчит үйлдвэрийн газар	7407.2	7663.1	255.90	3.45
Төсөл, сангууд	0.7	0	-0.70	(100.00)
Нийт дүн	110,057.4	113,647.5	3590.1	3.3

Хүснэгт-9

Нийт үндсэн хөрөнгө өмнөх оноос 3,3 хувиар өссөн байна. Үүнд: барилга байгууламж 8,9 хувь, зам гүүрийн байгууламж 15,1 хувь, түүх соёл, музейн дурсгал зүйл 2,7 хувь, бусад үнпсэн хөрөнгө 7,2 хувиар өссөн бол тээврийн хэрэгсэл 8,1 хувь, тавилга, эд хогшил 0,2 хувь, машин тоног төхөөрөмж 3,6 хувь, биет бус хөрөнгө 26,6 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Байгууллагын төрлөөр авч үзвэл ОНӨҮГ-уудын үндсэн хөрөнгө өмнөх оноос 3,45, төсвийн байгууллагын хөрөнгө 3,25 хувиар тус тус өссөн байна.

Нийт хөрөнгийн 93,3 хувийг төсөвт байгууллага, 6,7 хувийг төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудад ногдож байна.

Тайлант хугацаанд үндсэн хөрөнгө 16,903,5 сая төгрөгөөр /үүний дотор худалдан авсан 477,1 сая төгрөг, хандив тусламжаар 1948,5 сая төгрөг, шилжүүлж авсан 2187,9 сая төгрөг, бусад 12289,9 сая төгрөг/ нэмэгдэж, 8793,5 сая төгрөгөөр /үүний дотор худалдсан 18,5 сая төгрөг, акталсан 1531,5 сая төгрөг, шилжүүлсэн 2127,3 төгрөг, бусад 5116,2 сая төгрөг/ хасагдаж, тайлант онд 6153,2 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

Тайлант онд барилга байгууламж 9340,9 сая төгрөгөөр, машин тоног төхөөрөмж 1351,2 сая төгрөгөөр, тээврийн хэрэгсэл 712,4 сая төгрөгөөр нэмэгдэж, энэ нь улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бий болсон байна.

Үндсэн хөрөнгийн бүтцийг диаграммаар харуулбал:

**График-2**

Нийт үндсэн хөрөнгийн 0.3 хувийг газар, 68,9 хувийг барилга байгууламж, 2,3 хувийг тавилга, эд хогшил, 4,8 хувийг машин тоног төхөөрөмж, 11,3 хувийг дуусаагүй барилга, 4,3

хувийг зам гүүрийн барилга байгууламж, 2,4 хувийг тээврийн хэрэгсэл, 5,7 хувийг биет бус болон бусад үндсэн хөрөнгө тус тус эзэлж байна.

9.2 Үндсэн хөрөнгөтэй холбоотой зөрчлийн талаар

Хэнтий аймгийн ТЭЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар үндсэн хөрөнгөтэй холбоотой 2446,5 сая төгрөгийн дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

“Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн 77 дугаар зүйлийн 77.3-д “Орон нутгийн өмчийн үндсэн хөрөнгийг бусдын өмчлөлд шилжүүлэх, барьцаалах, шинээр олж авах асуудлыг гагцхүү ИТХ, түүний хуралдааны чөлөөт цагт Хурлын тэргүүлэгчид шийдвэрлэнэ” гэсэн заалтыг зөрчин холбогдох байгууллагын зохих шийдвэргүйгээр нийт 20,8 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн байна. Үүнд:

- “Хэнтий ус” ХХК 18,4 сая төгрөгийн, Хэрлэн сумын 6-р цэцэрлэг 0,3 сая төгрөг, Хэрлэн сумын 7-р цэцэрлэг 2,1 сая төгрөг, нийт 20,8 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн байна.

“Төсвийн тухай” хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д “Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккрузал суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлийг заавал бүртгэнэ”, 14.4.2-д “Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэсэн заалтыг зөрчсөн болон санхүүгийн тайлангийн оршин байх, иж бүрэн байх, үнэлгээ, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй нийт 2425,7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Аймгийн Нийтлэг үйлчилгээний газар үнэ төлбөргүй хүлээн авсан 30,0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг орлого үр дүнгийн тайланд бусад орлогоор тайлагнаагүй.
- Аймгийн ЗДТГ 573,9 сая төгрөгийн, Хэрлэн сумын 1-р сургууль 23,2 сая төгрөгийн, нийт 597,1 сая төгрөгийн хандив тусламжаар авсан үндсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгалгүй орхигдуулсан.
- Баянхутаг сумын ЭМТ 0,6 сая төгрөг, аймгийн ГХБХБГазар 5,7 сая төгрөг, Баянмөнх сумын ЕБС 12,0 сая төгрөг, нийт 18,3 сая төгрөгийн хөрөнгийг ангилалын дагуу үнэн зөв бүртгээгүй.
- Батширээт сумын Хот тохижилт 5,9 сая төгрөгийн үндсэн хөрөнгөнд элэгдэл байгуулаагүй, Баянмөнх сумын ЗДТГ үндсэн хөрөнгийн элэгдлийг 20,5 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн
- Баянхутаг сумын ЗДТГ 1749,2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдлийг эд хариуцагчтай тооцоо нийлсэн акт үйлдэж баталгаажуулаагүй, Бор-Өндөр сумын ЗДТГ 1,8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг санхүүгийн тайландаа зөрүүтэй илэрхийлсэн, Бэрх тосгоны цэцэрлэг 2,2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хасах бичилтийг алдаатай хийсэн байна.

Аудитаар нийт 2446,5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 1776,0 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч, 670,5 сая төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулсан байна.

Арав. Өр төлбөрийн бүртгэл, тайлагнал**10.1 Өр, төлбөрийн бүтцийн талаар**

Хэнтий аймгийн ТЭЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 3890.3 сая төгрөг байснаас тайланд онд 763.3 сая төгрөгөөр буурч, оны эцэст 3127.0 сая төгрөгт болсон байна.

Нийт өр, төлбөрийн үлдэгдлийг бүтэц, байгууллагын төрлөөр харуулбал:

(сая төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний	Эцсийн	Зөрүү	Хувь
	үлдэгдэл	үлдэгдэл		
Богино хугацаат өр төлбөр	1850.1	1,086.8	(763.3)	(41.2)
Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн зээл	127.3	59.6	(70.4)	(55.3)
Өглөг	1722.8	1027.2	(695.6)	(40.3)
Урт хугацаат өр төлбөр	2,040.2	2,040.2	-	-
Урт хугацаат үнэт цаас	-	-	-	-
Урт хугацаат зээл	2,040.2	2,040.2	-	-
Нийт өр төлбөрийн дүн	3,890.3	3,127.0	(763.3)	(19.6)
Үүнээс: Байгууллагын төрлөөр харуулбал:				
Төрийн сан	90.0	91.5	1.5	1.6
Төсөвт байгууллагууд	730.5	107.4	(623.1)	(85.2)
ОН-ын өмчит үйлдвэрийн газар	3040.6	2907.4	(133.2)	(4.3)
Төсөл, сангууд	29.2	20.7	(8.5)	(29.1)
Нийт өр төлбөрийн дүн	3,890.3	3,127.0	(763.3)	(19.6)

Хүснэгт-10

Тайлант хугацааны эцэст богино хугацаат өр төлбөр 763.3 сая төгрөгөөр буюу 41,2 хувиар буурсан дүнтэй байна. Нийт өр төлбөрийн 34.7 хувийг богино хугацаат өр төлбөр, 65.3 хувийг урт хугацаат өр төлбөр тус тус эзэлж байна. Нийт өр төлбөрийн 2,9 хувийг төрийн сан, 3,5 хувийг төсөвт байгууллагууд, 92,9 хувийг ОНӨҮГазар, 0,7 хувийг төсөл сангууд тус тус эзэлж байна.

Өглөгийн үлдэгдлийг сум тус бүрээр харуулбал:

(сая төгрөгөөр)

д/д	Аймгийн нэр	Нийт өр төлбөр /сая төгрөгөөр/		Зөрүү	Эцсийн үлдэгдэлийн нийт дүнд эзлэх хувь
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл		
1	ХБУлаан	3.31	3.09	-0.22	0.10
2	Цэнхэрмандал	5.32	3.28	-2.04	0.10

3	Дэлгэрхаан	11.25	9.02	-2.23	0.29
4	Мөрөн	12.80	9.57	-3.23	0.31
5	Баян-Адарга	12.98	4.08	-8.90	0.13
6	Өлзийт	14.85	7.98	-6.87	0.26
7	Дадал	15.39	3.88	-11.51	0.12
8	Баян-Овоо	17.04	14.52	-2.52	0.46
9	Батноров	17.31	3.75	-13.56	0.12
10	Галшар	19.05	1.33	-17.72	0.04
11	Дархан	20.11	1.12	-18.99	0.04
12	Баянхутаг	20.53	10.03	-10.50	0.42
13	Баянмөнх	20.87	9.35	-11.52	0.30
14	Гурванбаян	24.82	5.46	-19.36	0.17
15	Жаргалтхаан	26.51	3.67	-22.84	0.12
16	Биндэр	28.63	21.66	-6.97	0.69
17	Батширээт	29.54	6.70	-22.84	0.12
18	Өмнөдэлгэр	31.59	1.81	-29.78	0.06
19	Норовлин	32.05	15.29	-16.76	0.49
20	Бэрх	60.31	1.21	-59.10	0.04
21	Бор-Өндөр	186.43	10.65	-175.78	0.34
22	Хэрлэн	226.58	5.76	-220.82	0.18
23	Аймгийн төв	3,053.0	2,973.81	-79.23	95.10
	Дүн	3,890.31	3,127.02	(763.29)	100.0

Хүснэгт-11

Хүснэгтээс үзэхэд тайлант оны эцэст нийт өр төлбөрийн 2973.8 сая төгрөг буюу 95.1 хувь нь аймгийн, 5.7 сая төгрөг буюу 0.1 хувь нь Хэрлэн сум, 10.6 сая төгрөг буюу 0.3 хувь нь Бор-Өндөр сум, 4.5 хувь нь бусад сумдад оногдож байна.

Цаашид аймаг, сумын Засаг дарга нар Төсвийн тухай хуулийн “Өр, авлага үүсгэхгүй байх” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

10.2 Өр, төлбөрийн дансны үлдэгдлийн баталгаажуулалтын талаар

Хэнтий аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар өглөгийг буруу бүртгэсэн, тайланд тусгаагүй, өглөгийн үлдэгдлийг харилцагч байгууллага, иргэнтэй тооцоо нийлж актаар баталгаажуулалгүйгээр санхүүгийн тайлан, бүртгэлд тусгасан зэрэг нийт 18,4 сая төгрөгийн зөрчил илэрч, хэмжилт, иж бүрэн байх, тохиолдсон байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна. Үүнд:

- Цэнхэрмандал сумын ЭМТөв нь 0,1 сая төгрөгийн НДШ-ийн өглөгийг, Баянхутаг сумын ЭМТөв 0,2 сая төгрөгийн өглөгийг бүртгээгүй, Аймгийн Нийтлэг үйлчилгээний газар 0,5 сая төгрөгийн ААНОАТ-ын өглөгийг тайлагнаагүй.
- “Хэнтий-Ус” ХХК-ны санхүүгийн тайлан дахь байгууллагын өглөг дансны үлдэгдлийг тулган баталгаажуулахад “Бэрх-Уул” ХХК-ны өглөг 10,4 сая төгрөгөөр зөрүүтэй, Баянмөнх сумын цэцэрлэг 0,6 сая төгрөгийн өглөгийг дутуу тайлагнасан, 1,2 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, Бор-Өндөр сумын Бор-Өндөр хот тохижилт жилийн эцсийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, Байгаль орчин аялал жуулчлалын газар 1,9 сая төгрөгийн өглөгийг, Хэрлэн сумын 4 дүгээр цэцэрлэг 2016 оны эхний хагас жилд 3,4 сая төгрөгийн өглөгийг тус тус тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.
- Аймгийн ЗДТГ нь цалингийн зардал, өглөгийн дансдын бүртгэлийг стандартын дагуу бүртгээгүй, ажилчдын цалинг санхүүгийн программаар тооцоолж бүртгээгүй байдал нь мэдээллийг программаас шууд татах боломжоор хязгаарлагдмал болгосон байна.

Дээрх зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас өмнө хянан баталгаажуулах”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион багуулах, удирдах” гэсэн заалтыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

10.3 Хэнтий аймгийн ТЕЗ-аар дамжуулан олгосон урт хугацаат зээлийн эргэн төлөлтийн талаар:

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр 2004 онд нийтийн ахуйн үйлчилгээний ажлыг сайжруулах, дэмжих зорилгоор 2040,2 сая төгрөгийн төслийн урт хугацаат зээлийг “Хэнтий – Ус” ХХК-д олгосон байна. Аймгийн санхүүгийн нэгтгэсэн тайланд урт хугацаат зээлээр бүртгэгдсэн ба Тайлант онд уг өр төлбөрийн үлдэгдэлд өөрчлөлт ороогүй бөгөөд тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

Аймгийн аудитын газраас 12,3 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж, 6,1 сая төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулсан байна.

Арван нэг. Орлогын бүртгэл, тайлагнал

11.1 Хэнтий аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн талаар

2016 оны Хэнтий аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангаарх үйл ажиллагааны орлогын нийт дүн 78048,9 сая төгрөгөөр тайлагнасан бөгөөд өмнөх онтой харьцуулахад 23774,9 сая төгрөгөөр буурсан байна.

Нийт орлогын бүтцийг харуулбал:

(сая төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Зөрүү	Хувь
----------	----------	------------	-------	------


Татварын орлого	8,041.6	7,944.7	(96.9)	(1.2)
Татварын бус орлого	29,164.8	23,360.4	(5,804.4)	(19.9)
Тусламж санхүүжилтийн орлого	64,617.4	46,743.8	(17873.6)	(27.7)
Үйл ажиллагааны орлогын дүн	101,823.8	78048,9	(23774.9)	(23.3)

Хүснэгт -12

Дээрх хүснэгтээс харахад татварын орлого 96.9 сая төгрөг буюу 1.2 хувиар, татварын бус орлого 5804.4 сая төгрөг буюу 19.9 хувиар, тусламж санхүүжилтийн орлого 17873,6 сая төгрөг буюу 27,7 хувиар тус тус буурсан дүнтэй байна.

11.2 Сумдын ТЭЗ-ийн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан

Хэнтий аймгийн ТЭЗ-ийн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн үйл ажиллагааны орлогын нийт 46079,7 сая төгрөг буюу 59 хувийг 22 сум, 31969,3 сая төгрөг буюу 41 хувийг орон нутгийн төсөвт шууд захирагч байгууллагууд эзэлж байна. Үүнээс сумдын нийт орлогын дүнд эзлэх хувийг авч үзвэл:

Нийт орлогын дүнд эзлэх хувийн жинг сумдуудаар харуулбал: График-3

Дээрх графикаас дүгнэж үзвэл Хэрлэн, Бор-Өндөр, Батширээт сумдууд орлогын дүнгээр өндөр хувийг эзэлж байна.

11.3 Орлогын данстай холбоотой зөрчлийн талаар

Хэнтий аймгийн ТЭЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар орлогыг буруу бүртгэсэн, тайланд тусгаагүй, өөрийн орлогын төлөвлөгөөг тасалсан, төвлөрүүлэх орлогыг бүрэн төвлөрүүлээгүй зэрэг нийт 278,2 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнд:

- Биндэр сумын Төрийн сангийн нэгтгэсэн тайланд нийт орлогын эхний болон эцсийн үлдэгдлийг 222,6 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн;
- Биндэр сумын ЗДТГ, Батширээт, Баян-Адрага, Өмнөдэлгэр, Хэрлэн, Баянхутаг, Дадал, Норовлин, Бэрх, Мөрөн сумын цэцэрлэгүүд нийт 4,0 сая төгрөгийн орлогыг үндсэн үйл ажиллагааны орлогоор бүртгэж тайлагнаагүй, 15,4 сая төгрөгийн

жирэмсний болон амаржсаны, ХЧТА-ны тэтгэмжийн орлогын дансны бичилтийг алдаатай хийж үр дүнгийн тайланд орлогоор бүртгэсэн;

- Аймгийн ЗДТГ, Хан Хэнтий чуулга, Бор-Өндөр сумын хот тохижилтын газар зэрэг байгууллагууд орлогын төлөвлөгөөг нийт 8,6 сая төгрөгөөр тасалсан;
- “Хэнтий Ус”ХХК нь нэмэгдсэн өртгийн албан татвар 11,2 сая төгрөг, Биндэр сумын ЗДТГ, Бор-Өндөр сумын хот тохижилт нийт 1,4 сая төгрөгийн орлогыг төсөвт төвлөрүүлээгүй;
- Жаргалтхаан сумын ЕБС 14,1 сая төгрөгийн хандивын орлогыг санхүүгийн тайланд тусгалгүй орхигдуулсан байна.

Аудитаар илэрсэн нийт 278,2 сая төгрөгийн алдаа, зөрчлөөс 231,4 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлж, 12,5 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 34,3 сая төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулсан байна.

Арван хоёр. Зардлын бүртгэл, тайлагнал

12.1 Зардлын бүтцийн талаар

Хэнтий аймгийн ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайланд нийт зардал 71,856.5 сая төгрөгийн зарцуулалттай тайлагнагдсан нь өмнөх оноос 19,972.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хэнтий аймгийн ТЕЗ-ийн 2016 оны төсвийн нийт зарцуулалтыг үр дүнгийн тайланд бүрэн тайлагнасан байна.

Нийт зардлыг эдийн засгийн ангиллаар өмнөх болон тайлант онтой харцуулж үзэхэд:

(сая төгрөгөөр)


ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН	Зөрүү	Өсөлт бууралт ын ХУВЬ
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	91,829.0	71,856.5	(19,972.5)	(21.7)
УРСГАЛ ЗАРДАЛ	91,829.0	71,856.5	(19,972.5)	(21.7)
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	47,857.5	49,109.5	1,252.0	2.6
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	26,535.2	26,174.9	(360.3)	(1.4)
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,919.0	2,877.9	(41.1)	(1.4)
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,524.4	4,235.2	710.8	20.1
Хангамж, бараа материалын зардал	1,264.1	1,284.7	20.6	1.6
Нормативт зардал	2,338.0	2,361.0	23	0.1
Эд хогшил, урсгал засварын зардал	444.1	492.9	48.8	10.9
Томилолт, зочны зардал	184.7	177.2	(7.5)	(4.1)

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,477.0	2,057.1	580.1	39.2
Бараа үйлчилгээний бусад зардал	9,171.0	9,448.6	277.6	3.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,150.5	12,777.3	2,626.8	25.8
ТАТААС	150.4	174.3	23.9	15.8
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	33,670.6	9,795.4	(23,875.2)	(70.9)

Хүснэгт №13

Нийт зардлын дүнд зардлуудын эзлэх хувийг авч үзвэл:


(сая төгрөгөөр)

**График №4**

Дээрх графикаас харахад: 26,174.9 сая төгрөг буюу 36 хувийг цалингийн зардал, 12,777.3 сая төгрөг буюу 18 хувийг хөрөнгийн зардал, 9,795.4 сая төгрөг буюу 14 хувийг урсгал шилжүүлэг зэрэг зардлууд хамгийн өндөр хувийг эзэлж байна.

Сумдын нийт зардлыг авч үзвэл:

(сая төгрөгөөр)

**График-5**

Дээрх графикаас харахад: нутаг дэвсгэр, хүн ам, эдийн засгийн статусаар ялгаатай тул сумдаас Хэрлэн сум, Бор-Өндөр, Өмнөдэлгэр сум өндөр хувийг эзэлж байна.

12.2 Хэнтий аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар зардалтай холбоотой гарсан зөрчлүүдийн талаар

Хэнтий аймгийн ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар зардлын данстай холбоотой нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандарт, журам, зааврыг мөрдөөгүй, дансны бичилт буруу, анхан шатны баримтын бүрдүүлэлт дутуу, төсвийг зориулалт бусаар, үрэлгэн, үр ашиггүй бөгөөд холбогдох шийдвэргүйгээр зарцуулсан нийт 398,1 сая төгрөгийн алдаа, зөрчлүүд илэрч эдгээр нь үнэн зөв байдал, толилуулга, хэмжилт, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.

Хэнтий аймгийн ТЕЗ-ийн СНТ-д хийсэн аудитаар илэрсэн нийт алдаа зөрчлийг эдийн засгийн ангилалаар ангилж график №6-т дүрслэн харуулав. Нийт зөрчлөөс хамгийн өндөр буюу 44,2 хувийн 175,8 сая төгрөгийн зөрчил нь НББүртгэл, тайлагналтай, 35,9 хувийн 143,1 сая төгрөгийн зөрчил тогтмол зардалтай, 19,9 хувийн 79,0 сая төгрөгийн бусад зөрчлүүд эзэлж байна.

Илэрсэн зөрчлүүдийг ангилж үзвэл:

(Сая төгрөгөөр)




График №6

12.2.1 Илэрсэн зөрчлүүдийг зардлын нэр төрлөөр нь авч үзвэл:

Цалингийн зардал:

- Батширээт сумын ЭМТ 4 ажилтны 0,9 сая төгрөгийн ээлжийн амралтын цалинг бодож олгоогүй, Мөрөн сумын ЭМТөв 0,9 сая төгрөгний цалинг дутуу, цалингийн зардлаас 0,1 сая төгрөгийн шагнал олгосон.

- Батширээт, Цэнхэрмандал, Дархан, Мөрөн сумын ЭМТөвүүд 15,0 сая төгрөгийн үр дүнгийн урамшууллыг хавтгайруулан олгосон, Жаргалтхаан сумын ИТХ-ын дарга өөрөө өөртөө тушаал гаргаж 0,4 сая төгрөгийн буюу нийт 15,4 сая төгрөгийн урамшуулалыг олгосон.
- Аймгийн ЗДТГ, Батширээт, Биндэр сумын ЗДТГ нийт 4,1 сая төгрөгийн цалинг илүү олгосон бол Цэнхэрмандал сумын ЗДТГазар нь цалингийн зардлаас 0,2 сая төгрөгийн ажил олгогчийн НДШ-ийн зардлыг төлсөн, Хан хэнтий цогцолбор, Тэмүүжин цогцолбор, хүүхдийн ясли, Мөрөн сумын ЕБСургууль нийт 0,7 сая төгрөгийн цалинг НДШ-ийн тайланд тайлагнаагүй.
- Биндэр сумын ойн анги, Батширээт, Мөрөн, Баянхутаг сумын ЭМТөв нийт 0,2 сая төгрөгөөр, Хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтэс, Тэмүүжин цогцолбор сургууль, Ясли нийт 1,1 сая төгрөгөөр буюу нийт 1,3 сая төгрөгийн татварын хөнгөлөлтийг илүү эдлүүлсэн.
- Өмнөдэлгэр сумын ЭМТ 0,2 сая төгрөгийн ХХОАТ-ыг дутуу шилжүүлж өглөгөөр бүртгээгүй бол Баянхутаг сумын ЗДТГ 1,1 сая төгрөгийн даатгуулагчаас төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг илүү шилжүүлсэн.
- Биндэр сумын ойн анги, Баянмөнх сумын ЗДТГ нийт 3,2 сая төгрөгийн ХХОАТ-ын цалингаас суутган тооцоогүй
- Өмнөдэлгэр, Баянхутаг сумын ЭМТ, аймгийн Нийтлэг үйлчилгээний газар, Биндэр сумын ойн анги, Батширээт, Баянмөнх сумын ЭМТ, аймгийн ЗДТГ нийт 5,0 сая төгрөгийн НДШ-ийг дутуу тооцож тайлагнасан.
- Өмнөдэлгэр сумын ЕБСургууль, Хан хэнтий чуулга, Дархан сумын ЗДТГ 4,3 сая төгрөгийн тэтгэмжийг цалингийн зардлаас олгосон
- Бор-Өндөр сумын ЕБСургууль нь ажилтнаа үндэслэлгүйгээр ажлаас халж шүүхийн шийдвэрээр 1,1 сая төгрөгийн цалинг буцаан олгосон.

Хоолны зардал:

- Биндэр сумын цэцэрлэг хоол хүнсний материалыг 0,6 сая төгрөгөөр илүү зарлагдсан бол Хэрлэн сумын 4 дүгээр цэцэрлэг 0,4 сая төгрөгөөр дутуу тайлагнасан.
- Норовлин сумын ЕБСургууль бусад зардлаас 0,4 сая төгрөгийг үдийн цайны зардалд шилжүүлсэн бол Мөрөн сумын ЕБСургууль 0,2 сая төгрөгөөр, Хэрлэн сумын 8 дугаар цэцэрлэг 0,9 сая төгрөгөөр хоолны зардлыг тогтоосон хэмжээнээс хэтрүүлж, хүүхдийн хоолны тогтоосон нормыг баримтлаж ажиллаагүй.

12.2.2 Нягтлан бодох бүртгэл, тайлагнал, төсвийн зарцуулалттай холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

Зориулалт бусаар зарцуулсан зардлын талаар:

- Батширээт, Мөрөн сумын ЗДТГ, Хэрлэн сумын 1 дүгээр сургууль, Хан хэнтий цогцолбор сургууль, 4 дүгээр сургууль нийт 12,5 сая төгрөгийн зардлыг зориулалт бусаар зарцуулсан.
- Дадал, Цэнхэрмандал, Жаргалтхаан сумын ЗДТГазрууд Засаг даргын нөөц хөрөнгөөс шинэ жилийн арга хэмжээнд зориулж нийт 3,7 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан.

- Бэрх Жаргалтхаан, Өмнөдэлгэр сумын ЕБСургууль хичээл үйлдвэрлэлийн зардлаас 0,8 сая төгрөгийн, Хэрлэн сумын 1 дүгээр сургууль 10,9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн,
- Баян-Адрага, Цэнхэрмандал, Баянмөнх, Дархан, Жаргалтхаан сумын ЭМТөвүүд, Баянхутаг сумын ЕБС, Хэрлэн сумын Хан хэнтий цогцогцолбор сургууль, Хэрлэн сумын 3 дугаар цэцэрлэг урсгал төсвийн зардлаас нийт 17,5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн.
- Дадал, Норовлин, Баянхутаг сумын ЭМТөвүүд нийгмийн эрүүл мэндийн сургалт сурталчилгааны зардлаас нийт 8,8 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн.
- Батширээт, Биндэр, Баянхутаг, Баян-Адрага Жаргалтхаан, Өмнөдэлгэр, Бэрх, Дадал, Норовлин, Баянмөнх, Дархан, Бор-Өндөр сумын Нархан, Бүжинхэн, Энхжин, Хэрлэн сумын 1, 2, 4, 5, 7, 8 дугаар цэцэрлэгүүд Хүүхэд хөгжлийн хөтөлбөрийн зардлаас нийт 83,1 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн байна.

Санхүүгийн тайлагналтай холбоотой:

- Биндэр, Бэрх, Норовлин, Баянмөнх, Баянхутаг, Мөрөн, Хэрлэн сумын 1,2,3,4,5,6,7,8 дугаар цэцэрлэгүүд, Норовлин, Баянмөнх сумын ЭМТ, Бор-Өндөр сумын ЕБСургууль, Орон нутгийн музей нийт 175,2 сая төгрөгийн зардлыг санхүүгийн тайланд алдаатай илэрхийлсэн
- Баянмөнх сумын ЗДТГ 4,9 сая төгрөгийн цалингийн зардлыг шууд зардалд хаасан.
- Мөрөн сумын ЭМТ 10,0 сая төгрөгийн автомашиныг зохих шийдвэргүйгээр данснаас хассан зэрэг зөрчлүүд илэрсэн.

Дээрхи алдаа, зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 26 дугаар зүйлийн 26.1-д “Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккрузл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэсэн заалтуудыг зөрчиж, санхүүгийн тайлангийн “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 398,1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 219,8 сая төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулсан, 40,8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн, 7,9 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 127,3 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч, 2,3 сая төгрөгийн зөрчлийг гаргасан эрх бүхий албан тушаалтнуудад харицлага тооцох санал хүргүүлж ажилласан байна.

Арван гурав. Хэнтий аймгийн орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын бүртгэл, тайлагнал

13.1 ОНӨҮГ-ын талаар:

Хэнтий аймгийн ТЭЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд “Хэнтий ус” ХХК, Нийтлэг үйлчилгээ, Тохижилт үйлчилгээ, Эмийн эргэлтийн сан, өрхийн эмнэлэг, ой анги зэрэг нийт 42 ОНӨҮГ-ын санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна. Үүнээс 6 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийж дүгнэлт гаргаснаас 1 байгууллага “хязгаарлалттай санал дүгнэлт”, 5 байгууллын санхүүгийн тайланд “зөрчилгүй санал дүгнэлт” авсан байна.

13.2 Орон нутгийн өмчит байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар төрийн өмчтэй холбоотой зөрчлийн талаар

Аудитаар дараах алдаа, зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- “Хэнтий ус” ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээн дэхь төрийн өмчийн дүнгээс санхүүгийн тайлангаарх төрийн өмчийн дүн 3279.1 сая төгрөгөөр зөрүүтэй, байгууллагын дүрэмд төрийн өмчийн дүн, хувьцааны тоог тусгаагүй байна;
- “Батширээт ой анги”-ийн Төрийн өмчийн дүн Улсын бүртгэлийн гэрчилгээгээр 1,2 сая төгрөг, санхүүгийн тайлангаар 17,9 сая төгрөг буюу 16,7 сая төгрөгийн зөрүүтэйгээр тайлагнаж ирсэн байна.

Энэ нь Компаний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т дараах зүйлийг компанийн дүрмэнд заавал тусгана, 16.2.2-д “компанийн зарласан болон гаргасан хувьцааны тоо, тэдгээрийн төрөл, нэрлэсэн үнэ, **хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ**”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-д “Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь **өмч, хөрөнгийн** хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам хяналт тавих дотоод хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Аудитаар ОНӨҮГ-уудад нийт 3414,2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 36,2 сая төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулсан, 15,5 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 3362,5 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч ажилласан байна.

Арван дөрөв. Хэнтий аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийн талаар

Хэнтий аймгийн ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд орон нутгийн төсвийн байгууллага 58, тусгай зориулалтын шилжүүлэгийн байгууллага 109, халамжийн сан 1, ОНХСан 23, төсөл сан 72, төрийн сангийн нэгж 23, орон нутгийн өмчит 42 байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэсэн байна.

Аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллага, төсөл сан, орон нутгийн өмчит газрын нийт 98 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 167 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулан үзэж, 2 байгууллагын санхүүгийн тайланд итгэл үзүүлсэн болно.

Үүнээс дүгнэлт гаргасан байгууллагуудыг төрлөөр нь авч үзвэл :

- ✓ Төсөл сан -1
- ✓ Орон нутгийн төсөвт байгууллага 18
- ✓ ОНӨҮГазар-6
- ✓ Тусгай шилжүүлэг-58

Сумын ТТЗ -15 буюу нийт 98 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийсний 36,7 хувь буюу 36 нэгжид аймгийн Аудитын газар, үлдэх 63,3 хувь буюу 62 нэгжид хувийн аудитын компани аудит хийсэн байна.

Аудитаар Хэнтий аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллага, төсөл сан, сумын төрийн сан, ОНӨҮГ-уудын 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар материаллаг шинжтэй 711,0 сая төгрөг, материаллаг бус 6661,9 сая төгрөг, нийт 7372,9 сая төгрөгийн алдаа, зөрчил

илрүүлснээс 1242,2 сая төгрөгийн алдааг холбогдох санхүүгийн тайланд залруулж, 5613,7 сая төгрөгийн материаллаг бус алдаа, зөрчлийг засч залруулах 145 зөвлөмж өгч, 493,7 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 21,0 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 2,3 сая төгрөгийн зөрчилд холбогдох эрх бүхий албан тушаалтанд хариуцлага тооцох санал хүргүүлсэн байна. Зөрчлийг ангилж үзвэл:

- Мөнгөн хөрөнгийн дансанд буюу зарцуулахтай холбоотой 99,8 сая төгрөгийн буюу 1,3 хувь;
- Авлагатай холбоотой 442,1 сая төгрөгийн буюу 6,0 хувь;
- Бараа материалын дансны бүртгэл, зарцуулахтай холбоотой 89,8 сая төгрөгийн буюу 1,2 хувь;
- Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагналтай холбоотой 2446,5 сая төгрөгийн буюу 33,2 хувь;
- Өр, төлбөрийн бүртгэл, тайлагналтай холбоотой 17,9 сая төгрөгийн буюу 0,2 хувь;
- Орлогын бүртгэл, тайлагналтай холбоотой 278,2 сая төгрөгийн буюу 3,8 хувь ;
- Зардлын данс буюу зарцуулахтай холбоотой 397,3 сая төгрөгийн буюу 5,4 хувь;
- Төрийн өмчийн бүртгэл, тайлагналтай холбоотой 3295,8 сая төгрөгийн буюу 44,7 хувь;
- Санхүүгийн тайлангийн уялдаа холбоо, тайлагналтай холбоотой 304,7 сая төгрөгийн буюу 4,1 хувийн зөрчил тус тус илэрсэн байна.

Зөрчлийг дансны ангилалаар харуулбал:



График-7

Хэнтий аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллага, ОНӨҮГ, Төсөл сан, сумдын ТЕЗ-ийн нийт 98 санхүүгийн тайланд хийсэн аудитаар 95 тайланд “зөрчилгүй санал дүгнэлт”, 3 тайланд “хязгаарлалттай санал дүгнэлт” өгсөн байна.

Аудитын явцад хийсэн сорилын үр дүнд санхүүгийн тайлангийн батламж мэдэгдэлтэй зөрчилдсөн материаллаг хэмжээний алдаа, зөрчлүүд илэрсэн зарим ТШЗ, ОНӨҮГ-ын 2016 оны санхүүгийн тайланд өгөх санал дүгнэлтийг хязгаарлахад хүргэлээ. Үүнд:

“Хязгаарлалттай” санал дүгнэлт авсан байгууллагын жагсаалт:

№	“Хязгаарлалттай” санал,дүгнэлт авсан Хэнтий аймгийн ТШЗ, ТТЗ	“Хязгаарлалттай” санал, дүгнэлтийн шалтгаан
1	“Хэнтий ус” ХХК	➤ Санхүүгийн тайлангаар тайлагнасан борлуулалтын орлого, нэмэгдсэн өртгийн албан татварын тайлангаарх борлуулалтын орлого хоорондоо 111.9 сая төгрөгөөр зөрүүтэй, 11.19 сая төгрөгийн нэмэгдсэн өртгийн албан татварыг ногдуулж тайлагнаагүй, ➤ санхүүгийн тайлан дахь төрийн өмчийн дүн, улсын бүртгэлийн гэрчилгээн дэх дүнгээс 3279,1 сая төгрөгөөр зөрүүтэй, ➤ холбогдох байгууллагын зөвшөөрөлгүй 18.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан, ➤ нийт авлагын 92,9%, өглөгийн 35,6% нь тооцоо нийлсэн актаар баталгаажаагүй, ➤ өглөгийн тулган баталгаажуулалтаар 10,4 сая төгрөгийн зөрүү гарсан, ➤ хүүгийн орлогыг тусгайлсан хувь хэмжээтэй орлогоор тайлагнаж зохих татварыг ногдуулаагүй зэрэг алдаа зөрчил нь Татварын Ерөнхий хуулийн 18.1.1, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 5.2.1, 7.1.1, Компаний тухай хуулийн 3.5, 16.2, 16.2.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77.2.3, Төсвийн тухай хуулийн 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5, 20.2.6, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 9.1, 9.1.4 дэх заалтуудыг зөрчиж, санхүүгийн тайлангийн Эрх ба үүрэг, Оршин байх, Иж бүрэн байх, Толилуулга ба тодруулга, Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.
2	Баянмөнх сумын ЗДТГ	➤ Цалингийн зардлыг анхан шатны баримттай тулган шалгахад нийт 4890.4 мянган төгрөгийн цалинг тооцож олгохдоо олговол зохих цалинг тооцоолж бодоогүй гарт олгох цалингийн дүнгээр шууд цалингийн зардалд хаасан, ➤ Ажилчдын НДШ-ийн тооцоог хийхдээ тухайн сард цалин бодогдоогүй байхад НДШимтгэлийг тооцож шилжүүлсэн, зарим ажилчдын олговол зохих цалинг НДШ-ийн тайланд зөрүүтэй тайлагнасан жилийн эцэст НДХ, Татварын хэлтэст нийт 896.2 мянган төгрөгийг илүү шилжүүлсэн, ➤ НДШ-ийн тайланд зарим ажилчдын олговол зохих цалинг илүү дутуу буюу тооцож тайлагнаснаас 821.4 мянган төгрөгийг зөрүүтэй тайлагнасан, ➤ санхүүгийн тайлан гаргахын өмнө НДХэлтэс, ХХОАТ-ын хэлтэстэй тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүй, ➤ ЗДНСангаас сумын хүндэт тэмдгийн уралдаан зарлаж тэмдгийн хэвний 555.0 мянган төгрөгийн хөрөнгө нь биетээр ирээгүй байхад бичиг хэргийн бараа материалын тайланд хий орлогоор авсан зэрэг алдаа зөрчил илэрсэн байна.

		Энэ нь УСНББОУС-ын 1,12,17 стандарт, НББ тухай хуулийн 20.2.5, 13.7 дахь заалт, Үнэн зөв байдал, Эрх ба үүрэг, Иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.
3	Баянхутаг сумын ЗДТГ	➤ Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж мөрдөөгүй, ➤ 124 ширхэг 3,3 сая төгрөгийн малыг тоолоогүй, нас дэвшилт хийгээгүй, төлийн орлого аваагүй, ➤ 1677,6 сая төгрөгийн үндсэн хөрөнгөд тооллого хийж, тооцоо бодоогүй, ➤ 71,5 сая төгрөгийн барилга байгууламжийг тоолоогүй, ➤ 0,8 сая төгрөгийн авлагын үлдэгдэлд тооцоо нийлж баталгаажуулаагүй, ➤ түрээсийн орлогын 20 хувь болох 0,14 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй, ➤ санхүүгийн тайланд 0,4 сая төгрөгийн НДШ-ийн авлагыг тусгаагүй, ➤ НДШ-ийн зардлаас 1,0 сая төгрөгийг цалингийн зардалд гүйлгэн зарцуулсан зэрэг алдаа зөрчил илэрсэн байна.

Хүснэгт-14**Арван тав. Өмнөх оны аудитын зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны аудитаар нийт 4 зөвлөмж хүргүүлсэн бөгөөд СТСХэлтэс зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар тодорхой арга хэмжээ зохион байгуулж ажилласан байна.

Арван зургаа. Хэнтий аймгийн ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн санал, дүгнэлт

Хэнтий аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн материаллаг шинжтэй 711,0 сая төгрөгийн алдаа, зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшингээс хэтрээгүй тул Хэнтий аймгийн ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд “ЗӨРЧИЛГҮЙ” санал дүгнэлт өгч байна.

Арван долоо. Тайлант оны аудитын зөвлөмж

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна.

Хэнтий аймгийн ТЕЗ Н.Ганбямба-д:

1. Орон нутгийн өмчит аж ажуйн нэгж байгууллагуудын гэрчилгээ, компанийн дүрэмд өөрчлөлт оруулах талаар тодорхой арга хэмжээ зохион байгуулж зөрчлийг арилгах.
2. Засаг Даргын нөөц хөрөнгийг “**Засаг Даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам**”-ын 2.1, 2.3 дахь заалтыг үндэслэн, зориулалтын дагуу зарцуулах, шинэ жилийн болон баярын арга хэмжээг зохион байгуулахдаа төсвийн хөрөнгө зарцуулахгүй байх талаар сумын Засаг дарга нарт нэгдсэн чиглэл үүрэг даалгавар өгч, биелэлтэд хяналт тавьж ажиллах
3. Сумдын ЕБСургууль “хичээл үйлдвэрлэл”-ийн зардлаас, Хүүхдийн цэцэрлэг “хүүхэд хөгжил” хөтөлбөрийн зардлаас, ЭМТөв “нийгмийн эрүүл мэндийн сургалт сурталчилгаа”-ны зардлаас үндсэн хөрөнгө бэлтгэдэг зөрчлийг арилгахад тавих дотоод хяналтыг сайжруулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах талаар аймгийн БСУГ болон ЭМГ-т тодорхой үүрэг даалгавар өгч, биелэлтэд хяналт тавьж ажиллах.

СТСХ-ийн дарга С.Нямдаваа-д:

1. Сумдын Төрийн сангийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдэж буй байгууллагуудын мөнгөн хөрөнгө, авлага, өглөгийг бэлтгэн нийлүүлэгч, харилцагч байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үйлдэж, үлдэгдлийг баталгаажуулсны дараа санхүүгийн тайланг бэлтгэж байх талаар нэгдсэн чиглэл өгч, түүнд тавих дотоод хяналтыг сайжруулах.

Хэнтий аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд

Аудит хийсэн багийн гишүүд:

Ахлах аудитор

Шинжээч



Х.Еркегүл

М.Чулуун-Эрдэнэ



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

23119 Чингис хот, Хэнтий аймаг,
Утас/Факс: 70-56-21-51

2017.04.26 № 9/894
танай _____-ны № _____-т

АУДИТЫН ГАЗАРТ

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн талаар менежментийн захидлаар ирүүлсэн зөвлөмжийн төсөлтэй танилцлаа.

Танай байгууллагаас ирүүлсэн зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлж бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулахад чиглүүлж хэрэгжилтийг ханган ажиллах болно.



Н.ГАНБЯМБА

АА Х.Ерхмүрэг
Менежментийн захирал
Эдгээр дүртэй авуул
Хэрэгжилтийг дүн шинжилгээ
СН-аас шаардах
4/26